



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ 07 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2017.07.19

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Газрын Дуудлага Худалдаа, Төсөл Сонгон Шалгаруулалтын Талаар:

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Дархан сумын нутаг дэвсгэрт 3 дахь удаагийн газрын дуудлага худалдааг 2017.06.23-ны өдөр зохион байгууллаа.

Дуудлага худалдаанд 3 оролцогч оролцож 14-р баг Дархан-50 цогцолборын баруун талд 1500 м² үйлчилгээний зориулалттай газрыг иргэн М.Одончимэг 305 сая төгрөгөөр хамгийн өндөр үнэ хэлж ялагч болж худалдаж авсан.

**ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ДУУДЛАГА ХУДАЛДААНД
УРЬЖ БАЙНА.**

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/230 дугаар захирамжийн дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг танхимгаар зохион байгуулна.

Дуудлага худалдаа 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11:00 цагт аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд нээлттэй явагдана. Дуудлага худалдааны битүүмжилсэн материалыг 2017 оны 06 дугаар сарын 21-нээс 06 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минут хүртэл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүлээн авна.

Дуудлага худалдаанд оролцогч дэлгэрэнгүй мэдээлэл болон байршлын зургийг www.darkhan.gazar.gov.mn вэб хуудаснаас болон www.facebook.com/darkhanuul.landoffice фэйсбүүк хуудаснаас авах ба дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Дархан төрийн сангийн 100190029401 тоот дансанд тушаана уу.



1 Байршил: 14-р баг, Дархан-50 цогцолборын баруун талд
Талбайн хэмжээ: 1500 м²
Газрын зориулалт: үйлчилгээ /сургалтын төв/
Дуудах анхны үнэ: 90,000,000 төгрөг

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
Лавлах утас: 70376471, 95012529

2017 оны 7 дугаар сар 19-ны өдрийн байдлаар Газрын дуудлага худалдаанаас 401,6 сая төгрөг, газрын суурь үний орлогоос 50,09 сая төгрөг нийт 451,7 сая төгрөгийг орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Төсөл сонгон шалгаруулалтанд оролцож шалгарсан 14 иргэн, хуулийн этгээдэд аймгийн Засаг даргын газар эзэмшүүлэх захирамжийг гаргуулан БОНУ-г аймгийн БОАЖГ-аар хийлгүүлэн газар эзэмшүүлэх гэрээ байгуулан гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Газар өмчлөлийн талаар:

2017.07.20-ны өдрийн байдлаар Дархан суманд 34 иргэнд 2,8 га, Орхон суманд 78 иргэнд 5,68 га, Хонгор суманд 28 иргэнд 8,5 га газрын өмчлүүлсэн байна.

Бусад аймаг сумын нутагт газар өмчлөх эрхээ эдлэхээр хүсэлт ирүүлсэн 40 иргэнд Дархан суманд газар өмчлөөгүй тодорхойлолт гаргаж өгсөн.

Дархан сумын Засаг даргад Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэхь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэхь заалтын дагуу Дархан суманд хамтран өмчлөх эрхээсээ татгалзах хүсэлт ирүүлсэн 7, эзэмшил газраа өмчлөх хүсэлт ирүүлсэн 22, газар эзэмших эрхээ шилжүүлэх хүсэлт гаргасан 4 иргэн нийт 34 иргэний өргөдөл хүсэлтийг захирамж гаргуулахаар хүргүүллээ.


Геодези, зураг зүйн чиглэлээр:

“Ёлт сүрвэй” ХХК-аар хэмжилт хийлгэсэн 3 иргэний хэмжилтийн материалыг эргэлтийн цэг тэмдэгт хүлээлгэн өгсөн актын хамт хүлээн авч мэдээллийн санд оруулсан.


Кадастрын мэргэжилтэн ээлжийн амралт авсан тул ажлыг нь орлон гүйцэтгэж 35 иргэн, 12 аж ахуйн нэгжид кадастрын зураг гаргаж үйлчиллээ. Өмчлөлийн газрын өвлөх эрх шилжүүлсэн 1, худалдах, худалдан авах гэрээ хийсэн 5 иргэний эрх шилжүүлж мэдээллийн санд бүртгэсэн.



Үл хөдлөх хөрөнгийн хаяг дугаар авахаар өргөдөл, хүсэлт ирүүлсэн 10 дугаар багт байршилтай иргэн Б.Баярсайхан, 15 дугаар баг иргэн Д.Буянжаргалын нарын материалыг бүрдүүлж Дархан сумын ИТХ-д хүргүүлснээр 2017.07.05-ны өдрийн 42 дугаар тогтоолоор хаяг, дугаар олгосон.




БОАЖГ-аас ирсэн албан бичгийн дагуу нөхөн сэргээлт хийлгүй орхисон зөрчилтэй талбайн зургийг өгсөн солбицолын дагуу хийж хүргүүлсэн.



Зөрчилтэй талбайн зураг

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

2017.06.19-07.19





2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

”Хот байгуулалтын тухай” хуулийн 23, 24-р зүйлийн хэрэгжилтэнд холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг хийх, хяналт тавьж ажиллах:

- Газрын харилцааны хянан шийдвэрлэх хуралд оролцсон.
- Шарын гол сумын 150 хүүхдийн дотуур байрны талаар “Энигма” ХХК, БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ-н хяналтын инженерүүдтэй хамтарсан хурал хийж, уг барилгын ажлын явцын талаар хэлэлцэж шийдвэр гаргав.

Ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын чиглэлээр:

- 2018 оны төсөвт тусгах зорилгоор Дархан сумын 7,14,30-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Орхон Хонгор сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэх төсөвт өртгийн тооцоо гаргав.
- 2018 оны улсын болон орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлэхээр ойрын үед хийгдэх шаардлагатай инженерийн шугам сүлжээний ажлын тоо хэмжээг гаргаж өгсөн.
- Дархан сумын 8-р багт хүүхдийн тоглоомын талбайн 2ш, Малчин баг Хөтөл хороололд хүүхдийн тоглоомын талбайн 1ш байршлын зураг гаргав.
- Эх загвар зураг 1ш хянаж баталсан. Үүнд:Орхон сум Энхтал багт Дархан шандас трейд үйлчилгээний барилга.
- Шарын гол суманд 2017 онд “ газар эзэмших эрхийн төсөл сонгон шалгаруулалт”-аар олгохоор төлөвлөсөн 4 нэгж талбарын архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулж, батлуулан хүргүүлсэн.
- Дархан сумын 8-р багт 2 байршилд хүүхдийн тоглоомын талбай байршуулж байршлын зураг хийсэн.
- Дархан-Уул аймгийн Дархан сум, 3-р багийн иргэд олноор зорчдог замыг хэсэгчлэн засаж тэгшлэх зориулалтаар төсөл сонгон шалгаруулж олгох газрын байршлын зураг хийв.

Засгийн газрын 68 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- Дархан-Уул аймаг, Дархан сум, Малчин багт байршилтай “Юнигаз” ХХК-ний автомашин хийгээр цэнэглэх станцын барилгын ажил эхлүүлэх хүсэлтийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэхэд барилга байгууламжийн зураг төслийн экспертизийн ерөнхий дүгнэлт дутуу байсан тул барилгын техникийн бичиг баримтаа бүрдүүлсний дараа барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлөө дахин хүсэх тухай албан бичгийг өгч ажилласан.

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 9-р багт байршилтай “Дархан Өүлэн Эх” ХХК-ний зочид буудал, үйлчилгээний барилгын ажил үргэлжлүүлэх хүсэлтийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэхэд газар эзэмших эрхийн хугацаа дууссан, барилга байгууламжийн өөрчлөлтийн экспертизийн дүгнэлт дутуу байсан тул барилгын техникийн бичиг баримтаа бүрдүүлсний дараа дахин хүсэлтээ гаргах тухай албан бичгийг хүргүүлж ажилласан.

- Барилга угсралтын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг бүрдүүлсэн техникийн бичиг баримтыг хянаж үзэн дараах барилга байгууламжид олгосон. Үүнд:

1. Дархан сум 11-р баг, 9-р сургуулийн хажууд Иргэн Д.Загарын зорьтой 7-н давхар үйлчилгээний барилга
2. Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р багт байршилтай 2200 хүний суудалтай спорт, соёл үйлчилгээний цогцолбор



3. Дархан-Уул аймаг, Дархан сум. Малчин баг. 3-н шарын урд “Юнигаз” ХХК-ны өргөтгөл
4. Дархан-Уул аймаг, Дархан сум 7-р багт байршилтай “ВВЭН” ХХК-ны авто үйлчилгээний барилга

Засгийн газрын 69 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Доорх барилгуудад ирүүлсэн хүсэлт, техникийн бичиг баримтын иж бүрдэл, ажлын гүйцэтгэлийг хянан үзэж, барилга ашиглалтад авах комиссын бүрэлдэхүүнийг зохион байгуулж ажиллуулан ашиглалтад хүлээн авав.

- Дархан сум 13-р баг. Дархан нутаг” ТББ-н нутгийн ордоны барилга
- Дархан сум 14-р баг. Иргэн Мөнхтөрийн Үйлчилгээний барилга
- Дархан сум 5-р баг. Иргэн Даландэлгэрийн Үйлчилгээний барилга
- Дархан сум 3-р баг. ХАСВУУ” ХХК-н төмөр бетон шонгийн үйлдвэр

Барилгын тусгай зөвшөөрөл олгох журамд заасны дагуу:

- Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрөл авах, сунгах хүсэлт гаргасан 2 компанид техникийн бичиг баримтыг хянаж үзэн Барилгын хөгжлийн төвд тодорхойлолт гаргаж ажилласан. Үүнд:

1. Дархан-Уул аймаг, Дархан сумын 14-р багт байрлалтай 1911017110 тоот улсын бүртгэлтэй, 4265122 регистрийн дугаартай “Уран Хараат” ХХК-ний барилга угсралтын нэмэлтээр 2.2.2, 2.2.6 заалт.
2. Дархан-Уул аймаг, Дархан сумын 10-р багт байрлалтай 1911017150 тоот улсын бүртгэлтэй, 4265866 регистрийн дугаартай “Төгс Иксора” ХХК-ний барилга угсралтын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах.
3. Гурван эрдэнэ цемент” ХХК-н чулуунцар тээрэмдэх үйлдвэрийн тусгай зөвшөөрөл сунгах материал болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж тодорхойлолт гаргав.

Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр:

- БХБЯ-д хөгжлийн банкнаас барилга материалын үйлдвэрлэлийн чиглэлээр зээл авсан “Эко ноос” ХХК, “Дархан трейд” ХХК-н мэдээллийг хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлээ.

- Дархан сумын үйлдвэрийн районд байрлалтай барилгуудын тоо хэмжээ, судалгааг гаргах ажлыг үргэлжлүүлэн хийж, 21 үйлдвэрийн барилгад судалгаа авах тухай албан бичиг хүргүүлээд байна. Үүнээс:

1. “Эйч Эс Эм Жи” ХХК
2. Магнай трейд ХХК
3. Материал техник хангамжийн бааз
4. “Энсдатракрон” ХХК
5. Сод монгол нефтийн агуулах
6. Авто машин механизмын бааз
7. Чин удам
8. Эрдэс хөвөнгийн үйлдвэр
9. Байшин үйлдвэрлэх комбинат
10. Керамзитын үйлдвэр
11. Дундын авто машин механизмын бааз зэрэг газруудад Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс аж ахуй нэгж байгууллагуудад харъяаллын барилга, байгууламжийн мэдээллийг нэг бүрчлэн гаргаж өгөх судалгааг төлөвлөн биеэр хүргэж өгсөн.



- 2018 оны төсөвт тусгуулах шаардлагатай байгаа лабораторийн нэмэгдэл тоног төхөөрөмжийн жагсаалт /29,4 сая төг/ гаргаж ня-бо-д өгсөн

**Инженерийн хангамжийн техникийн нөхцлийн хэрэгцээт ачаалал 15-18-р
үлгэрчилсэн загвар мөрдөж ажиллах талаар:**

- Дулааны техникийн нөхцөлийн хэрэгцээт ачааллыг 15 иргэн, ААНБ-д
- Ус хангамж, ариутгах татуургын хангамжийн хэрэгцээт ачааллыг 4 иргэн, ААНБ-д тооцож гаргаж өгсөн байна.
- “ДДС” ТӨХК дээр техникийн нөхцөл олгох хуралд оролцож 18 иргэн, ААНБ-н гаргасан хүсэлтийг хэлэлцэж, 14 иргэн ААНБ-д техникийн нөхцөл олгох шийдвэр гаргалаа.

**Улс, орон нутаг болон бусад эх үүсвэрээс санхүүжилттэй шинээр болон шинэчлэн
боловсруулж буй хот байгуулалтын баримт бичигт санал өгөх, гүйцэтгэгчтэй
хамтран ажиллах:**

- Дархан-Улаанбаатар хотын хооронд тавигдах 30 км авто замын зургийн эхний хэсгийг баталж, замын доорхи шугам сүлжээний зургуудыг дуусахлаар авчирч хянуулах тухай даалгаврыг ерөнхий гүйцэтгэгч компанид өгсөн.
- Дархан сум 16-р баг. Иргэн Энхээгийн худалдаа үйлчилгээний барилгын гадна цахилгааны 0,4кВ кабель шугамын зургийг хянасан.

**Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн
заавар”-ыг мөрдөж ажиллах, мэдээллийн сан бүрдүүлэх:**

- Жижүүрийн ерөнхий төлөвлөгөөний хөтлөлтөд баяжилт хийгдлээ.
 - “Баргил тех” ХХК-н гадна цахилгаан хангамжийн шугамын 6кВ шугам
 - Дархан сум. 7-р багт тавигдсан хатуу хучилттай авто замын зураг
 - Дархан сум. 3-р баг. Хасвуу ХХК-н цахилгаан хангамжийн шугам

Барилга захиалагчийн техник хяналтын талаар:

- Дархан-Уул аймаг, Шарын гол суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 150 хүүхдийн дотуур байрны барилга угсралтын явцад гаргасан зөрчлийн талаар БХТ-ийн хяналтын инженер Б.Түмэн-Өлзий, Б.Оюунсүвд, Дархан-Уул аймгийн МХГ-ын барилга угсралтын улсын байцаагч С.Цэвэлправжаа, ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Х.Олонбаяр, мэргэжилтэн Х.Туул, С.Ундрах болон гүйцэтгэгч “Энигмо констракшн” ХХК-н дэд захирал Бямбажаргал, инженер Б.Эрдэнэболд Хонгорзул нар оролцсон хурал хийж ярилцсаны эцэст барилгын бетоны хийц бүрээс дээж авч итгэмжлэгдсэн лабораториар шинжлүүлж дүгнэлт гаргуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн.

3.БУСАД АЖИЛ

- Шарилжгүй Дархан хөтөлбөрийн хүрээнд 12 иргэн, аж ахуй нэгж байгууллагад албан бичиг өгсний дагуу 10 иргэн аж ахуйн нэгж байгууллага барилгын түр хашаан доторх шарилжаа устгаж фото зургаар баталгаажуулж өгсөн. Дархан сумын 11-р багт байршилтай Иргэн С.Байгалмаа, С.Галсандоржийн барилгын түр хашаан доторх шарилжийг удаа дараа цэвэрлэх шаардлагыг тавьсан боловч шарилжаа цэвэрлээгүй байна.

- Аймгийн ЗДТГ-т албан хаагчдыг сургаж хөгжүүлэх сургалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайланг хүргүүллээ.

- Эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайланг дуусгаж тайлангаа хамгаалав.

- Газрын даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж, ажилтнуудын эхний хагас жилийн тайланг хэлэлцэн дүгнэлт гаргав.




- Аймгийн Захирагчийн албанд байгуулагынхаа гадна тохижилтын ажлын тухай тайлан хүргүүллээ.
- ГХБХБГ-н даргын аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хагас жилийн ажлын биелэлт гаргасан.
- Аймгийн Засаг даргын БХБ-н сайдтай байгуулсан гэрээний хагас жилийн ажлын тайлан гаргаж аймгийн ХОХБТХ-т хүргүүлсэн.
- Хяналт шинжилгээ, үнэлгээний багийн 2017 онд хийх, гүйцэтгэл сайжруулах” ажлын төлөвлөгөөний II улирлын хэрэгжилтийн тайланг гаргасан.

Сургалт зохион байгуулсан талаар:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Цвейцарын хөгжлийн агентлаг "Ногоон-Алт малын эрүүл мэнд төсөлтэй хамтран "Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх, мэдээлэл боловсруулах тайлан гаргах" сэдэвт сургалтыг 2017 оны 7 дугаар сарын 3-4-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн сургалтын танхимд зохион байгууллаа.

Сургалтанд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын Инженер хайгуул, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон сумдын /Дархан-Уул аймгийн 3, Сэлэнгэ аймгийн 17-н сумын газрын даамлууд/ газрын даамлууд хамрагдлаа.

Сургалтаар бэлчээрийн ургамлыг аж ахуйн бүлгийн түвшинд таних чадварыг эзэмшүүлэх, фото мониторингийн мэдээг боловсруулалтын чанарыг сайжруулан улмаар бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загвар ашиглан үнэлгээ, үр дүнг тайлагнах чадвар эзэмшүүлэх зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулсан ба Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт хээрийн дадлагын ажлыг хийсэн.





Мэдээлэл технологийн чиглэлээр:

Байгууллагын цахим болон фэйсбүүк хуудсанд 12 мэдээ мэдээллийг оруулж, мөн байгууллагын серверийн хэвийн үйл ажиллагааг хангах, дотор өрөөний температур хэт халуун байгаатай холбогдуулан хуучин байсан хөргүүрийг шилжүүлэн суурилуулсан.



Хөргүүр шилжүүлж байгаа нь

2017 оны 4 сарын сүүлээр Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдуудын Газрын даамлуудад 4-н ширхэг цахим хурлын камерын худалдан авалтыг хийж энэ ажлын хүрээнд 7 дугаар сарын 19-нд Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон, Шарын гол сумдын Газрын даамлуудтай онлайнаар цахим хурлын камерыг турших ажлыг амжилттай зохион байгуулж хийсэн.



Байнгын ажиллагаатай станцын интернетийн дата багц дууссантай холбогдуулан дахин 1 жилийн хязгааргүй дата багцыг худалдан авч хэвийн үйл ажиллагаанд оруулсан.



Гадна тохижилтын талаар:

2017 онд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 20-н жилийн ой тохиож байгаатай холбогдуулан 20-н бүтээлч ажил хийж байгаагийн нэг байгууллагын гадна тохижилтын ажил бөгөөд зоорийн давхар руу ордог хэсгийн хуучин үүд нурах аюултай болсон тул буулгаж, шинээр дахин барих ажил хийгдэж байна. Мөн байгууллагынхаа үүдэнд 2 ш арслан хийлгүүлэн байрлуулж, байгууллагын гаднах



хашааны будаж, шинээр явган хашаа хийж, 2 ш сандал, 2 ш хогийн савыг байрлуулан байгууллагынхаа өнгө үзэмжийг нэмэгдүүлсэн.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

С.БАТБИЛЭГ
/Архив, бичиг хэргийн эрхлэгч/

ТАЙЛАН ХЯНАСАН:

А.НАРМАНДАХ
/Газрын удирдлагын хэлтсийн дарга/